



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 475

Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн
зээлээр суралцуулах, тушаалд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны захиалгаар Төрбатын Амартуулыг АНУ-ын Lindenwood-ийн их сургуулийн магистрантурт Уул уурхайн эдийн засгийн чиглэлээр 1,5 жилийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Батмөнхийн Мөнхзулыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Chonbuk-ийн их сургуулийн магистрантурт Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр 2 жилийн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар Ганхүүгийн Байгалмааг Австрали Улсын Melbourne-ийн их сургуулийн магистрантурт Эрх зүйн чиглэлээр 1,5 жилийн, Гадаад харилцааны яамны захиалгаар Рэнцэнбатын Надмидцэдэнг АНУ-ын Strayer-ийн их сургуулийн магистрантурт Олон улсын эрх зүйн чиглэлээр 2 жилийн, Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар Дангаагийн Нямбатыг АНУ-ын Missouri-ийн их сургуулийн магистрантурт Олон улсын эрх зүйн чиглэлээр 2 жилийн, Гадаад харилцааны яамны захиалгаар Хүрэлбаасангийн Энхгэрэлийг АНУ-ын Lindenwood-ийн их сургуулийн магистрантурт Олон улсын эрх зүйн чиглэлээр 1 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Халтарын Энхжаргалыг Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны академийн Дулааны физикийн хүрээлэнгийн докторантурт Эрчим хүчний төлөвлөлт, стратегийн чиглэлээр 2 жилийн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Батсүрэнгийн Түвшинбатыг Австрали Улсын Macquarie-ийн их сургуулийн магистрантурт Агаарын тандалт, судалгааны чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Доржжанцангийн Мөнхцэцэгийг АНУ-ын California-ийн их сургуулийн магистрантурт Соёл, урлагийн удирдлагын чиглэлээр чиглэлээр 2 жилийн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Болдбаатарын Түвшинтунгалагыг Австрали Улсын Үндэсний их сургуулийн магистрантурт Газар зохион байгуулалт, газрын харилцааны чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Баярсайханы Энхмөрөнг БНХАУ-ын Газрын тосны их сургуулийн магистрантурт Газрын тосны чиглэлээр 2 жилийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Гантулгын Энхболорыг АНУ-ын Strayer-ийн их сургуулийн магистрантурт Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Ишдоржийн Батболдыг АНУ-ын Devry-н их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Галсангийн Бодьбилгүүнийг АНУ-ын Devry-н их сургуулийн магистрантурт Компютер, программ хангамжийн чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны

2.

15
 захиалгаар Жамбалдоржийн Өлзийчимэгийг Япон Улсын Токиогийн их сургуулийн магистрантурт Газар тариалангийн чиглэлээр 2 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Ганцагааны Занданг АНУ-ын Virginia-ийн Олон улсын их сургуулийн магистрантурт Олон улсын худалдааны чиглэлээр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Ганбаярын Отгонбаярыг АНУ-ын Strayer-ийн их сургуулийн магистрантурт Олон улсын худалдааны чиглэлээр 2 жилийн, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны захиалгаар Эрдэнэ-Очирын Мөнх-Эрдэнийг БНСУ-ын Инчөний их сургуулийн магистрантурт Уул уурхайн эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2."Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 391 дүгээр тушаалын Цэрэндоржийн Насанжаргалтай холбогдолтой хэсгийн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар" гэснийг "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар" гэж өөрчилсүгэй.

3.Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР